



ХЭНТИЙ АЙМАГ
БАЯН-ОВОО СУМ, МОНГОЛ АРДЫН НАМ
Жавхланта 4-р баг, Утас: 99035910

2022.04.19 № 05
танай _____-ны № _____-т

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Монгол Аймаг, нийслэл сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн 2021 оны нөхөн сонгуульд Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Монгол Ардын намын хорооны 2020 оны мөрийн хөтөлбөрөөр оролцоно. Тус мөрийн хөтөлбөрийн эдийн засгийн тооцоололд өөчлөлт ороогүй болно.

ДЭД ДАРГА



Н.ЦОЛМОНБАЯР

ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯН-ОВОО СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМААС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД ДЭВШҮҮЛСЭН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Монгол Ардын намын хороо нь 2020 оны УИХ-ын сонгуульд Монгол ардын намаас дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр болон Хэнтий аймгийн Монгол Ардын намын хорооны хөтөлбөрт тулгуурлан дараах мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр дэвшүүлж байна.

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

- 1.1 Эхийн эрүүл мэнд, эсэн мэнд төрөх, хүүхэд мэндлэх бүхий л боломжоор хангахын тулд эхийн амрах байрыг байнгын ажиллагаатай болгож амрах эхчүүдийн тоог жил бүр нэмэгдүүлэх.
- 1.2 Ахмад настанд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулахын тулд ахмадын эмчтэй болох.
- 1.3 Хүн амын эрүүл мэндийг хамгаалах анхан шатны тусламжийн хөнгөн шуурхай хүргэж, багийн эмч нарын ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж, иргэдийн санаачлаганд тулгуурлан унаажуулах.
- 1.4 Эмийн эргэлтийг сангийн бие даасан байдлыг хангаж, эмийн хангалт, хүртээмжийг сайжруулах.
- 1.5 Ахмад настнуудыг урьдчилан сэргийлэн үзлэг оношлогоонд жил бүр хамаруулж, ахмадын сувилалыг сумын эрүүл мэндийн төвийг түшиглэн байгуулах.
- 1.6 Эрүүл аж төрөх ёсыг хүн амын бүхий л түвшинд сургах, амьдралын буруу зуршлаас урьдчилан сэргийлэх, зан үйлийг өөрчлөх зорилтот хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж сургалтыг зохион байгуулах.
- 1.7 Эмч, эмнэлгийн ажилтан, эрүүл мэндийн төвийн албан хаагчдын ажлын санал санаачлагыг бүрэн дүүрэн дэмжиж, урамшуулж ажиллана.
- 1.8 Сумын төвийн ундны усны худгийн тоог нэмэгдүүлж, ус цэвэршүүлэх тоног төхөөрөмжийг шинэчлэж, худгийг ухаалаг хэлбэрт шилжүүлж шаардлага хангасан ундны усаар хүн амыг хангах.
- 1.9 Хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтийг сайжруулж дугуйн спорт, роликын талбайг хийх.



Handwritten signature and official red stamp of the Bаян-Овоо Sum Citizens' Khural. The stamp contains the text: МОНГОЛ АРДЫН НАМЫН АНХАН ИЛ АЛТНЫ ХӨТӨЛБӨР ХЭНТИЙ АЙМАГ • ООУОХ

- 1.10 Суманд спорт заал бариулж, фитнес цогцолборыг байгуулах.
- 1.11 Бүх нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар бүс нутаг, улс дэлхийн аварга шалгаруулах спортын уралдаан тэмцээнд оролцогчдод дэмжлэг үзүүлэх сан байгуулах.
- 1.12 Сургуулийн өмнөх насны бүх хүүхдийг цэцэрлэгт бүрэн хамруулж, багшлах боловсон хүчнийг чадавхжуулан, сургалтын орчинг сайжруулж, анги танхимыг тохижуулна.
- 1.13 Цэцэрлэгийн хүүхдүүдийн эцэг эхчүүдтэй хамтран тоглоомын талбайг шинэчлэх.
- 1.14 Хүүхэд бүрийг чанартай боловсрол эзэмших боломжийг олгож, багш нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилго бүхий “Боловсрол – Нутгийн хөгжил” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.15 ЕБС-ийн хичээлийн байранд их засвар хийж, суралцах таатай орчин нөхцлийг бүрдүүлнэ.
- 1.16 Малчдын хүүхдүүдийг 100 хувь дотуур байранд хамруулах.
- 1.17 Соёлын төвийн тоног төхөөрөмж, техник уэрэгсэл, хувцас хэрэглэл хөгжимын зэмсгээр хангах ажлыг шат дараалан авч хэрэгжүүлнэ.
- 1.18 “VIP CINEMA” байгуулах.
- 1.19 Элсэлтийн ерөнхий шалгалтанд өндөр оноо авсан, авъяас чадвартай сум орон нутагтаа нэн шаардлагатай мэргэжлээр суралцах болсон, суралцаж буй сумандаа эргэн ирж ажиллаж, амьдрах хүсэлтэй сурагчид, оюутнуудад зориулсан “Сумандаа сайхан амьдраъя” хөтөлбөрийг хэрэгжүүлэх.
- 1.20 Тус суманд үйл ажиллагаа явуулж байгаа ашиглалтын компаниудтай хамтран “Жонш” хөтөлбөрийг хэрэгжүүлж ажилгүйчүүдийг түр ажлын байраар хангах ажлыг зохион байгуулах.
- 1.21 Сумын түүх, соёлын биет болон биет бус өвийн лавлагаа мэдээллийн санг бий болгож самбаржуулах.
- 1.22 Орон нутгийг судлах танхим байгуулах.
- 1.23 Сумын төвийн байгууллага аж ахуйн нэгж, айл өрхүүдийг үргэлжлүүлэн инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлж, цэвэрлэх байгууламж бариулах.

1
Амгун
11

13171442
40046 90



1.24 ЭКО жишиг орон сууц төслийн хүрээнд хямд үнэтэй орон сууц бариулж иргэдийг орон сууцаар хангах ажлыг зохион байгуулах.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2.1 Сумын брэнд бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгож “Баян-Овоо брэнд” төслийг хэрэгжүүлнэ.

2.2 Малын ашиг шим, үүлдэр угсааг сайжруулах, мал аж ахуйн түүхий эдийн бэлтгэлийг нэмэгдүүлэх, үнэгүйдлээс хамгаалах зорилгоор анхан шатны боловсруулалт хийх арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

2.3 Малыг эрүүлжүүлэх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг чанаржуулж, хувийн мал эмнэлгүүдэд тавих төрийн болон малчдын хяналтыг сайжруулан жил бүр тайланг Багийн Иргэдийн нийтийн хуралд тавиулж хэлэлцүүлэх.

2.4 Суманд малжуулах төслийг хэрэгжүүлж, залуу малчдыг дэмжиж ажиллах.

2.5 Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж малчдын саналд тулгуурлан худаг гаргах, сэргээн засварлах, булгийн эхийг хашиж хамгаалах зэрэг арга хэмжээнүүдийг шат дараатай авч хэрэгжүүлнэ.

2.6 Мал аж ахуйн түүхий эд, мал нядалгааны төвтэй болох.

2.7 Сумыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг бодит ажил болгохыг эрчимжүүлэх ба газар зохион байгуулалтыг ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан цэгцэлнэ.

ГУРАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

3.1 “Өрх бүр – Нэг мод” хөдөлгөөнийг жил бүр өрнүүлж ажиллах.

3.2 Төмс хүнсний ногоо тариалан, чацаргана хөтөлбөрт хамрагдах, хүлэмж болон ногооны бүлэг байгуулах зэрэг оролцооны бүхий л санал санаачилга, бүтээлч ажлуудыг дэмжинэ.

3.3 Бэлчээрийн менежментийн бодлогыг хэрэгжүүлнэ.

3.4 Газар тариалан, тэжээлийн ургамал тариалах боломжийг судлах.

3.5 ЭКО сум болгох хөдөлгөөнийг өрнүүлж ажиллана.



3.6 Байгаль орчныг хамгаалах асуудалд иргэн бүрийн анхаарлыг хандуулж, байгаль орчноо хайрлан хамгаалах ухамсар мэдлэг олгох, сургалтуудыг зохион байгуулах.

3.7 Сумын төвийн ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн, ногоон зурвасуудыг шинээр байгуулж, байгаа ногоон байгууламжуудын ашиглалт, үйлчилгээг сайжруулах.

3.8 Хог хаягдлын хэмжээг бууруулах, дахин ашиглах, байгальд ээлтэй байдлаар цэвэрлэх, зайлуулах хог хаягдлын менежментийн бодлогыг сумынхаа онцлогт тохируулан боловсруулан хэрэгжүүлж, хогны машины тоог нэмэгдүүлж ашиглалтыг сайжруулах.

3.9 Сумын аялал жуулчлалын сүлжээ, маршрутыг бий болгох.

3.10 Гүрмийн нуур аялал жуулчлалын бааз амралт сувиллын газрыг байгуулах.

3.11 Сумын төвд шинээр газар эзэмших, өмчлөх эрх авч кадастрын зураглалд орсон газруудад цахилгааны шугам тавих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

3.12 “Манай гудамж – Гэрэлтэй гудамж” төслийг хэрэгжүүлж гэр хорооллын гэрэлтүүлгийг сайжруулах ажлыг иргэдийн оролцоо идэвхи санаачилганд тулгуурлаж шийдвэрлэх.

3.13 Аялал жуулчлалын бүс нутгийн хүрээнд Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумаас тус сумыг хатуу хучилттай замаар холбогдох ажлын судалгаа, төсвийг хийлгэж холбогдох газруудад уламжилж шийдвэрлүүлэх арга хэмжээг авч ажиллах.

3.14 Сумын ЗДТГ-ын барилгыг шинээр бариулах.

3.15 Баян-Овоо сум байгуулагдсаны 100 жилийн ойг угтаж амжилт бүтээлийн гурав жилийн аяныг зохион байгуулах.

3.16 Улаанбаатар чиглэлийн зорчигч тээврийн үйлчилгээг холбогдох байгууллагуудтай хамтран бий болгох.

ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

4.1 Иргэний нээлттэй танхимын үйл ажиллагааг сайжруулан аливаа төсөл хөтөлбөр, тендер сонгон шалгаруулалтыг иргэдэд ил тод, нээлттэй явуулах бодлого баримтална.

4.2 “Орон нутгийн хөгжлийн сан, “Сум хөгжүүлэх сан”, Жижиг дунд бизнесийг дэмжих сан” гаас зарцуулагдах хөрөнгөнөөс зээл олгогдохдоо багт зарцуулах зээлийн



сангийн хөрөнгийг тодорхой болгон багийн иргэдийн нийтийн хурлаар төслүүдийг хэлэлцэж шийдвэрлэдэг тогтолцоог бий болгоно.

4.3 Архинд хамааралтай хүмүүст туслан, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж тэдэнд дэмжлэг үзүүлнэ.

4.4 Төрийн ажил үйлчилгээг ил тод, авилгаас ангид хүнд сурталгүй болгож нэг цэгийн үйлчилгээний чанарыг дэвшүүлж. “Иргэдээ сонсьё” суурин утас ажиллуулж санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэх нөхцөл бололцоог бүрдүүлнэ.

4.5 Төрийн албан хаагчдыг шилж сонгох, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөлийг сайжруулж тэднийг идэвхжүүлэх тогтолцоог бий болгоно.

4.6 Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны нээлттэй тунгалаг байдлыг хангаж, төрийн нууцад хамаарахаас бусад мэдээлэлтэй иргэд чөлөөтэй танилцах боломжийг бүрдүүлнэ.

4.7 Төсвийн ил тод байдлыг хангаж, сумын төсвөөс зарцуулах хөрөнгийг бүх шатны байгууллагаас иргэдэд мэдээлэх, тайлагнах “ Ил тод төсөв” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

4.8 Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гарсан хэрэг зөрчлийг илрүүлэхэд дэмжлэг үзүүлж, мал хамгаалах малчдын бүлгийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, малын хулгайгаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.

4.9 Сумын авто замын сүлжээний гол болон туслах уулзваруудад замын хөдөлгөөний тэмдэг, тэмдэглэгээг хийлгэж телекамерийн системийг бий болгож, гүүрний авто зам дагуу хяналтын постыг шаардлагатай үед ажиллуулах.

4.10 БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат хотын Баян-Овоо дүүрэг, Эрээн хотын монгол сургууль, Өмнөговь аймгийн Баян-Овоо сум, Баянхонгор аймгийн Баян-Овоо сумтай “Баян-Овоочуудын түншлэл” хүрээнд хамтын ажиллагааг үргэлжлүүлэх.

The image shows a handwritten signature in black ink over a circular red official stamp. The stamp contains the text 'МОНГОЛ УЛСЫН ХӨРӨН АЖИЛЛАГААНЫ ХАМГААГАХ ХЭНГИЙН ХӨРӨН' (State Agency for Quality Assurance of Education and Science) and 'ХӨВД АЙМАГ' (Khovd Aimag). The number '15' is also visible within the stamp.